



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
АРВАЙХЭЭР СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2018 оны 06 сарын 14 өдөр

Дугаар 27

Арвайхээр

Орон нутгийн өмчийн тооллогын  
дүнгийн тухай

Орон нутгийн өмчийн тооллогын дүнгийн тухай Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч Ж.Ганзориг, Аж ахуйн нярав Б.Сэргэлэнбаатар нарын сонсголыг хэлэлцээд ТЭМДЭГЛЭХ нь:

Сумын орон нутгийн засаг захиргааны байгууллагын үндсэн хөрөнгө 2017 оны дүнгээр 36.810.775.058.73 (Гучин зургаан тэрбум найман зуун арван сая долоон зуун далан таван мянга тавин найм) төгрөгийн хөрөнгөтэй байна.

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 18.1.3-ийн “л”, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах тухай” 24 дүгээр тогтоолын 3.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Орон нутгийн өмчийн тооллоготой холбогдуулан байгууллагын актлах болон шилжүүлэх хөрөнгийг жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Нийтийн зориулалтай өмчийг холбогдох хуулийн дагуу ашиглаж, хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга бөгөөд Хотын Захирагч (О.Пүрэвдорж)-д үүрэг болгосугай.

ДАРГА



ДАМАРТҮВШИН